


# ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2021-2022 ОНЫ ХАМТ /ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭР

Энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээр нь Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа тул 2021 оны 06.... сарын 08.-ний өдөр бүртгэв.

Бүртгэлийн дугаар.....

Улаанбаатар хот

2021 он



## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, “Хөдөлмөрийн тухай” хуулийн II дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.5, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.5, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээрийг байгуулж байна.

Хэлэлцээрийн зорилго нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэх, үйлдвэрлэлийн үр ашигтай, тогтвортой үйл ажиллагааг хангахад оршино.

### Нэг. Ерөнхий зүйл

- Салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн эрчим хүчний салбарын өмчийн хэлбэр харгалзахгүй бүх аж ахуйн нэгж, байгууллагууд хамтын гэрээ байгуулан харьяа нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэн мөрдеж ажиллана.
- Салбарын аж ахуйн нэгжийн захиргаа, ҮЭ-ийн хороо хамтын гэрээний биелэлтийг мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу хагас, бүтэн жилээр ЭХЯ, МЭХГҮҮ-н ҮЭ-ийн холбоонд заавал тайлагнана.
- Хамтын хэлэлцээрт оролцогч талууд хэлэлцээрийг хэрхэн биелүүлж байгаа явц, үр дүнг хагас жил тутам дүгнэж, салбарын хэмжээнд хэлэлцээрийн хэрэгжилттэй танилцаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Захиргаа нь үйлдвэрийн болон салбарын хэвийн найдвартай ажиллагааг хангах, зайлшгүй тохиолдолд үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай санал солилцон өндөржүүлсэн дэглэм тогтоон ажиллуулж болно.
- Хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэх эдийн засгийн үндэс нь ажил олгогчдын санхүүгийн чадавх тул салбарын аж ахуйн нэгжүүд орлого, ашгаа нэмэгдүүлэхэд Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо (цаашид салбарын ҮЭ-ийн холбоо гэх), мэргэжлийн холбоод Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд бодлого, шийдвэрээрээ дэмжиинэ.
- “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол улсын Засгийн газрын 2013 оны 370 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар талууд бүх түвшинд хамтран ажиллана.
- Салбарын аж ахуйн нэгж, байгууллага бүр Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд өмнөх хүрсэн түвшинг дордуулахгүйгээр энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн хамтын гэрээг байгуулж мөрдеж ажиллана.
- Эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүлэх, цахилгаан дулаан үйлдвэрлэхэд зарцуулж буй бодит өртгийг үнэд шингээн энэ салбарын ажилтнуудын хөдөлмөрийг шударгаар үнэлэх эдийн засгийн боломжийг бүрдүүлэх талаар Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний яамтай хамтран ажиллана.

### Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн талаар



- 2.1 Ажлын байрыг олноор цөөрүүлэх, хөдөлмөрлөх нөхцөл байдлыг дордуулахад хүргэх орон тоо, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ аж ахуйн нэгж байгууллага /ажил олгогч/ нь нэг сарын өмнө холбогдох үйлдвэрчний эвлэлийн байгууллагад урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хангах, нийгмийн хамгааллын талаар тусгай гэрээ байгуулж, орон нутгийн хөдөлмөр зохицуулалтын албандаа бичгээр мэдэгдэнэ.
- 2.2 Салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг бичгээр 2 хувь байгуулж, хөдөлмөр эрхлүүлэх бөгөөд уг гэрээндээ хамтын гэрээ, хэлэлцээрт заасан нийгмийн баталгаа, нөхцөлийг хангахаар тусган тохирно.
- 2.3 Монгол улсын хуулийн дагуу Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг өөрчлөн зохион байгуулах, хувьчлах тохиолдолд ажиллагчид болон өндөр насын тэтгэвэрт гарсан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас групп тогтоолгосон ажилтнууд /иргэд/-ын нийгмийн хамгааллын асуудлыг шинэ бүтцээр зохион байгуулагдан хувьчилж авсан байгууллага хариуцна.
- 2.4 Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урт хугацаагаар сул зогсоох, өөр байгууллагатай нэгтгэхэд Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай урьдчилан зөвшилцэж байна.
- 2.5 Салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, салбарын ҮЭ-ийн холбоо болон салбарын аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байсан хугацааг тус салбарт удаан жил ажилласанд тооцно. /Орон тооны ҮЭ-ийн хороодын дарга нарт нэг адил хамаарна/
- 2.6 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон тахир дутуугийн групп тогтоолгосон ажилтан, мөн өндөр насын тэтгэвэрт гарсан ахмадуудыг ажил олгогчийн санаачлагаар тэдний мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг ашиглах зорилгоор өөрийнх нь эрүүл мэндэд харшлахгүй ажлын байраар хангаж болно.
- 2.7 Шинээр батлагдан гарсан хөдөлмөрийн харилцаа, хүний эрх болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хуулиудыг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг компанийн захиргаа, ҮЭ-ийн хороо хамтран зохион байгуулна.
- 2.8 Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь запуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудад чиглэсэн бодлого явуулж жендерийн тэгш оролцоог хангаж ажиллуулж болно.
- 2.9 Салбар болон үйлдвэр аж ахуйн нэгжид тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд захирлын дэргэд ахмадын зөвлөх баг ажиллуулж болно.

### **Гурав. Цалин хөлсний талаар**

- 3.1 Салбарын аж ахуйн нэгж, компани бүр үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж, хэрэглээний ба үйлдвэрлэлийн үнэ, тарифын өсөлт, эрчим хүчний алдагдлын бууралт, батлагдсан зардлын хэмнэлт, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн улсын 3 талт хэлэлцээрийн заалтыг үндэслэн жил бүр ажилтнуудын албан тушаалын үндсэн ба тарифт цалинг 2022 онд 5 хувиас доошгүйгээр нэмэгдүүлнэ. (Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоолыг хэрэгжүүлэх)
- 3.2 Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1,6 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Салбарын аж ахуйн нэгж байгууллагууд нь Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг




ажилтан, албан хаагчдын өндөр насны тэтгэвэр тогтоолгох, нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх, мөнгөн шагнал олгох, дагалдан ажилтны цалин хөлсийг тогтооход хэрэглэнэ.

- 3.3 Салбарын аж ахуйн нэгж байгууллагууд нь байгууллагын хүчин чадал, эдийн засгийн чадавхаас хамаарч Хөдөлмөр Нийгмийн Зөвшлийн Гурван Талт Үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дараах итгэлцүүр хүртэлх хэмжээгээр үргүүлж тооцно. Салбарын хэмжээнд төсөвт ажил гүйцэтгэхэд тарифыг аж ахуйн нэгж бүр дагаж мөрдөнө. /Эрчим хүчний салбарын мэргэжлийн зэрэг, түүний итгэлцүүр/

№	Үзүүлэлтүүд	Мэргэжлийн зэрэг					
		I	II	III	IV	V	VI
1	Итгэлцүүр	1.0	1.11	1.25	1.44	1.66	1.92

	Байгууллага	Үйл ажиллагааны чиглэл	Нөхцөл	
			Хэвийн	Хэвийн бус
1	“ДЦС-4” ТӨХК, “ЦДУС” ТӨХК, “УБТЦС” ТӨХК, “УБДС” ТӨХК, “ЭХДҮТ” ХХК, “ДЦС-3” ТӨХК	ашиглалт	2.6	2,75
		Засвар	2.4	2.6
2	“БНЗӨБЦС” ТӨХК, “Да-Сэ ЦТС” ХК, “Дарханы ДЦС” ТӨХК, “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК, “ДЦС-2” ТӨХК, “ДБЭХС” ТӨХК, Эрдэнэт-Булганы ЦТС ТӨХК, ӨБЦС ТӨХК, Эрчим хүчний барилга, засвар угсралтын компаниуд	ашиглалт	2.2	2.4
		Засвар	1.9	2.2
3	Бусад ДЦС болон ДС, цахилгаан түгээх сүлжээ, дамжуулах сүлжээ, дулааны шугам сүлжээ	Ашиглалт	2.1	2.3
		засвар	1.9	2.1
4	аймаг орон нутгийн эрчим хүчний (дизель ба сэргээгдэх эрчим хүч) систем, байгууллага	Ашиглалт	2.0	2.2
		засвар	1,8	2.0

- 3.4 Ажил, ажилчдын түгээмэл мэргэжлийн тариф мэргэшлийн лавлахыг Эрчим хүчний яам, Салбарын ҮЭ-ийн холбоо хамтран хянаж мөрдүүлэх бөгөөд ажил олгогч батлагдсан орон тоогоо үндэслэн инженер техникийн ажилтнуудын “Ажлын байрны тодорхойлолт”, “Ажил, ажилчдын мэргэжил, тариф мэргэшлийн лавлах”-ыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдөнө.
- 3.5 Тасралтгүй ажиллагаатай аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын байранд ээлжээр ажилладаг ажилтнуудад шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг албан тушаалын үндсэн ба тарифт цалингийн 50 хувиар бодож олгоно.
- 3.6 Байгууллагын тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 хүртэлх сарын албан тушаалын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний урамшууллын санг



эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтооно. Тухайн ажилтан албан хаагчийн жилийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын үндсэн ба тариифт цалинтай тэнцэх хэмжээний жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тогтоосон санд багтаан олгож болно.

- 3.7 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтээ арга барилаар мэргэжлийн үр чадвар гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтанд сар бүр үр чадварын нэмэгдэл олгож болох боловч энэ нь үндсэн цалингийн 40 хувь хүртэл байна.
- 3.8 Сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл үр дүнд үндэслэн тухайн хамт олны хамт олны /үйлдвэрийн цех хэлтэс, албадын/ албан тушаалын үндсэн болон тариифт цалингийн 50 хүртэл хувиар бодож олгоно.
- 3.9 Оновчтой санал, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх замаар зардал хэмнэсэн тохиолдолд хэмнэлтийн 20% хүртэл хэмжээнд урамшуулалт олгож болно.
- 3.10 Эрчим хүчний салбарт тасралтгүй ажиллаж байгаа ажилтанд удаан жил ажилласны нэмэгдлийг тус салбарт ажилласан хугацаанаас хамааруулан хөдөлмөрийн хэвийн нөхцөлд албан тушаалын болон үндсэн цалингийн 35 хүртэл, хэвийн бус нөхцөлд албан тушаалын болон үндсэн цалингийн 40 хүртэл хувиар бодож олгоно.
- 3.11 Ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлсийг сард хоёр удаа тогтоосон хугацаанд олгож байна.
- 3.12 Ажил мэргэжил хавсран, хослон, орлон ажилласны нэмэгдлийг хавсран, хосолсон, орлон ажилласан албан тушаалын цалингийн 40 хувиар бодож олгоно.
- 3.13 Байгууллагын хөдөлмөрийн аварга, хүндэт дэвтэрт бичигдсэн ажилтныг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, ажил мэргэжлийн аваргыг эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр шагнана.
- 3.14 Эрчим хүчний тэргүүний ажилтанд сар бүр 10 мянган төгрөг, гавьяат ажилтан, төрийн шагналтан, хөдөлмөрийн баатар болон тус салбарт ажиллаж байгаад бусад салбарын тэргүүний ажилтан болсон иргэнд нэмэгдэл урамшуулалт олгох асуудлыг тухайн байгууллага хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлнэ.
- 3.15 Эрчим хүчний салбарт үр бүтээлтэй ажилласан ажилтнуудын нэг удаагийн мөнгөн шагналыг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцон урамшуулалт олгоно.
- 3.16 Эрчим хүчний яам, салбарын ҮЭ-ийн холбооноос хамтран олгож байгаа “Тэргүүний мастер” цол тэмдгээр шагнагдсан ажилтанд 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөс доошгүй дагалдах урамшууллыг үндсэн байгууллага нь олгоно.
- 3.17 “Монгол Улсын төрийн дээд шагнал /Төрийн соёрхолт, Гавьяат ажилтан, Хөдөлмөрийн баатар/-аар шагнагдсан салбарын ажилтан, өндөр настанд тухайн ажиллаж байгаа болон харьялагдах байгууллагаас Төрийн соёрхолт болон Гавьяат ажилтанг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин, Хөдөлмөрийн баатарыг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин үржүүлсэнтэй тэнцэх нэг удаагийн мөнгөн урамшууллыг тус тус олгоно.
- 3.18 Эрчим хүчний зөвлөх инженерт албан тушаалын 20 хувьтай, мэргэшсэн инженерт үндсэн цалингийн 15 хувьтай тэнцэх хэмжээний хүртэл нэмэгдэл урамшууллыг бүтээлийн тайлан, үр дүнг үндэслэн олгож болно.



- 3.19 Төрийн өмчит компаниудын хэмнэлт болон үйлдвэрлэлийн бус өөрийн үйл ажиллагаанаас орох орлогыг төлөвлөгөөнөөс давуулан биелүүлсэн орлого ашгаас тухайн байгууллагын ажиллагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах асуудлыг хамтын гэрээндээ тусган шийдвэрлэх арга хэмжээ авна.
- 3.20 Сахилгын нэг төрөлд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулж ногдуулахгүй байх зарчмаар сарын болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг ногдох хувиар олгоно.
- 3.21 Салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудын цалин хөлсний өнөөгийн түвшинг буюу ажилтнуудын нийт орлогыг бууруулахгүй байх зарчмыг баримтлан зарим нэмэгдэл цалин хөлс, урамшууллыг тодорхой хэмжээгээр үндсэн цалинд шилжүүлэн оруулах замаар үндсэн цалинг ажилтнуудын үүрэг хариуцлага, мэргэшлийн түвшин, мэргэжлээрээ ажилласан жил зэргээс хамааруулан тогтоох талаар судалгаа хийх, санал боловсруулах үүрэг бүхий Эрчим хүчний яам, салбарын ҮЭ-ийн холбоо, ажил олгогч эздийн төлөөлөгчдийн хамтарсан ажлын хэсгийг томилж ажиллуулна.

#### **Дөрөв. Ажилтнуудын мэргэжил, боловсролын талаар**

- 4.1 Захиргаа нь Үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас зохион явуулж байгаа сургалт, семинар болон бусад үйл ажиллагаанд ажилтнуудыг хамруулан оролцуулна.
- 4.2 Ажилтны ажлын байрны сургалтыг аж ахуйн нэгж, байгууллага бүр тусгай төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулж, гарын авлага, компьютер, бусад техник хэрэгслээр хангана.
- 4.3 Аж ахуйн нэгж байгууллагын зардлаар тухайн байгууллагад шаардлагатай мэргэжлээр гэрээний үндсэн дээр дотоодын их, дээд сургууль, коллежид мэргэжилтэн бэлтгэж болно.
- 4.4 Хөдөө орон нутгийн эрчим хүчний байгууллагуудыг инженер, техникийн ажилтнаар хангахад анхаарч мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор мэргэжлийн сургуулиудтай хамтран ажиллана.
- 4.5 Захиргаа, ҮЭ-ийн байгууллага хамтран нийт ажилчдын 30 хувиас доошгүй хувийг сургалтад хамруулна.
- 4.6 Ажлын байран дээр сургалт зохион байгуулж хичээл заасан багш нарт олгох хөлсийг хэлцлийн журмаар тогтооно.
- 4.7 Салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулж, шинэ арга барил, ажлын туршлага, мэдээлэл солилцуулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- 4.8 Эрчим хүчний болон бусад мэргэжлээр их, дээд сургууль, коллеж төгссөн, курсээр мэргэжил эзэмшсэн иргэнийг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр дагалдангаар ажиллуулах тохиолдолд үндсэн цалинг эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс баагүйгээр тогтоон олгоно.
- 4.9 Эрчим хүчний салбарын хэмжээнд хийгдэж байгаа техник, технологийн шинэчлэлт, хүний нөөцийн бодлогын дагуу ажилтнуудын мэргэжил, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа сургалтад суралцагчдад сургалтын хугацаанд албан тушаалын сарын үндсэн цалинг олгоно.
- 4.10 Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр өгөөжийг сайжруулах үүднээс эрдмийн зэрэг хамгаалахаар судалгааны ажил хийж буй ажилтанд нэг удаа 2-3 сарын цалинтай чөлөө олгож болно.



## Тав. Нийгмийн асуудлын талаар


- 5.1 Ажилтнуудад үйлчилдэг гуанз, цайны газрын өдрийн хоолны үнийг 60 хувиар хөнгөлнө.
- 5.2 Халаалтын улирлын хөнгөлөлтийг нийт ажилтанд нэг зуун мянган төгрөгөөр бодож олгоно. /Энэ заалт ахмадууд YO, МШӨ-ний групптэй хүмүүс, хүүхэд асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд адил хамаарна. Нэг өрхийн хэд хэдэн гишүүн байдаг бол зөвхөн нэг хүнд хамаарна./
- 5.3 Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үүднээс рашаан сувилалд сувилуулсны зардлыг Улсын чанартай магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувиллын илгээх бичгийг үндэслэн жилд 1 удаа 50 хувиар хөнгөлнө. /Энэ заалт ахмадууд YO, МШӨ-ний групптэй хүмүүс, хүүхэд асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд нэг адил хамаарна./
- 5.4 Хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтанд жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр мөнгөн тэтгэмж олгоно.
- 5.5 Ажилтны төрсөн эцэг эх, эхнэр нөхөр, хүүхэд нас барж уй гашуу тохиолдоход салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлнэ. /Нэг байгууллагад гэр бүлийн болон ахан дүүс, хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд олгоно./
- 5.6 Захиргаа нь ажилтан болон ахмадуудаас ирсэн өргөдлийг үндэслэн тухайн өрхийн нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй, З хүртэл насын хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүд, тухайн байгууллагаас өндөр насын тэтгэвэрт гарсан ахмадууд, тахир дутуугийн группд орсон хүмүүс, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчиний улмаас нас барсан хүний ар гэрт, мөн өрх толгойлсон эхчүүд, эрчүүд, бүтэн өнчин үлдсэн айлын нэг хүүхдэд зайлшгүй мөнгөн тусламж үзүүлэх шаардлагатай бол жилд нэг удаа салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлж болно.
- 5.7 Ажилтан зуурдаар болон өвчиний улмаас нас барвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.
- 5.8 Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаад өндөр насын тэтгэвэрт гарсан ахмадууд, YO, МШӨ-ний групптэй хүмүүс нас барсан тохиолдолд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж үзүүлнэ.
- 5.9 Эрчим хүчиний салбарт ажиллаж байгаад өндөр насын тэтгэвэр тогтоолгосон ахмадуудад тухайн салбарт ажилласан жил тутамд эрчим хүчиний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр бодож нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно.
- 5.10 Тэтгэвэрт гарах өргөдлөө гаргаж тэтгэмжийн зардал нь төсөв төлөвлөгөөнд тусгагдсан ажилтан тэтгэвэр тогтоолгохоос өмнө нас барах нөхцөлд төсөвт тусгагдсан тэтгэмжийн зардлын 50 хувийг гэр бүлд нь олгох асуудлыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлнэ.
- 5.11 Эрчим хүчиний салбарт ажиллаж байгаад YO, МШӨ-ний улмаас группд байгаа иргэдээс өөрсдийн хүсэлтээр өндөр насын тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд эрчим хүчиний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тухайн байгууллагад ажилласан жилээр үржжүүлж нэг удаа тэтгэмж олгоно.
- 5.12 Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын дунд урлаг, спортын наадмыг зохион байгуулна.



- 5.13 Байгууллагын нэрийн өмнөөс олон улс, улс, салбарын чанартай биеийн тамир, урлаг, уран сайхны тэмцээн, уралдаанд оролцон амжилт гаргасан ажилтныг хамтын гэрээнд тусган шагнаж урамшуулж болно.
- 5.14 Захиргаа нь орон сууцгүй ажилтнуудыг орон сууцтай болгох зорилгоор хөрөнгийн эх үүсвэрийг гаргах, зээлээр орон сууц баруулах, худалдан авч өгөх, дэмжлэг үзүүлэх асуудлыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлнэ.
- 5.15 Захиргаа нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад бодит хувь нэмэр оруулсан ажил төрлийн холбоо бүхий аж ахуйн нэгж байгууллагуудын холбогдох хүмүүсийг шагнан урамшуулж болно.
- 5.16 Ажилтнуудын ажилдаа ирж, очих унааны зардал, зайлшгүй шаардлагаар хотын нийтийн тээврийн унаагаар албан үүргээ гүйцэтгэдэг ажилтнуудын унааны хөнгөлөлтийн асуудлыг тухайн байгууллага нь хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлнэ.
- 5.17 Эрчим хүчний салбарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байрыг цөөрүүлэх, орон тоог цомхтгох, хувьчлагдах тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор өмчийн хэлбэр үл харгалзан уг ажилтанд тус салбарт 1-4 жил ажилласан бол 4 сар, 5-10 жил ажилласан бол 8 сар, 11-15 жил ажилласан бол 12 сар, 16 ба түүнээс дээш жил ажилласан бол 24 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг бодож олгоно.
- 5.18 Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлд өртөж орон гэргүй болсон, эд хөрөнгийн хохирол учирсан ажилтанд хохирлын хэмжээг харгалзан үзэж нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.
- 5.19 Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн дагуу нөхөн төлбөр олгохыг байгууллага хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлнэ.
- 5.20 Нийгмийн хамгаалалтай холбоотой асуудлуудыг тухайн байгууллага эдийн засгийн боломжид тулгуурлан хамтын гэрээгээрээ зохицуулна.
- 5.21 Эрчим хүчний салбарын байгууллага бүр Ахмад настны тухай хуульд заасны дагуу Ахмадын сан байгуулан ажиллана.

### **Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар**

- 6.1 Үйлдвэрлэлийн осол гараагүй аж ахуйн нэгж байгууллага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг үлгэр жишигээ зохион байгуулсан ажилтан, аж ахуйн нэгжийг урамшуулах журам боловсруулж, шалгаруулан сурталчилж ажиллана.
- 6.2 Онцлог зарим ажлын байрны нөхцөлийн үнэлгээг ажил олгогч мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг бууруулах арга хэмжээг жил бүр авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ анагаах үр нөлөөтэй орон нутгийн рашаан сувиллын газартай хамтран ажиллаж, сувилуулагчдад хөнгөлөлт үзүүлэх талаар гэрээ байгуулан ажиллаж болно.
- 6.3 Аж ахуйн нэгж, байгууллагуудад бүтээмжийн хөдөлгөөнийг өрнүүлэх, ажлын байрны эрүүл ахуйн орчныг бүрдүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.
- 6.4 Жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд үйлдвэрлэлийн ослоор амь эрсэдсэн, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн ослоор групп тогтоолгосон хүмүүст хүндэтгэл үзүүлж осол аваар гаргахгүй байх ажлыг аж ахуйн нэгж бүр зохион байгуулж байна.



- 6.5 ХАБЭА талаар үндэсний 5 дахь хөтөлбөрийг аж ахуйн нэгж бүр хэрэгжүүлж ажиллана.
- 6.6 Жил бүр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н асуудлаар салбарын хэмжээнд зөвлөгөөнийг талууд хамтран зохион байгуулах ба ISO 45001 стандартыг хэрэгжүүлнэ.

### **Долоо. Үйлдвэрчний эвлэлийн эрхийг хангах талаар**

- 7.1 Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд заасан эрх, баталгааг хангахын зэрэгцээ ажил олгогч нь:
  - Аж ахуйн нэгж байгууллагын эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны тухай мэдээлэл өгч байна.
  - Үйлдвэрчний эвлэлийн хорооны бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн гишүүний татварыг цалингаас бэлэн бусаар хурааж, ҮЭ-ийн хорооны дансанд шилжүүлнэ.
- 7.2 Үйлдвэрчний эвлэл нь дараах үйл ажиллагааг явуулахын зэрэгцээ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
  - Хамтын гэрээ, хэлэлцээр хийх, батлах, явц үр дүнг хэлэлцэх
  - Хамтын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан хичээл, семинар, зөвлөгөөн хийх
  - Үйлдвэрчний байгууллагад тавьсан аливаа санал гомдлыг авч хэлэлцэх
  - Үйлдвэрчний эвлэлийн бүх гишүүдийн хурал хийх
  - Ажил олгогчтой тохиролцсоны дагуу зохион байгуулах бусад арга хэмжээ
- 7.3 Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуулыт ажилтныг хамтын гэрээнд хамруулан жилийн болон сар, улирлын ажлын үр дүнгийн шагнал, цол, мэргэшлийн нэмэгдлийг захиргаа олгоно. Мөн олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа ажилтнуудыг төр засгийн шагнаалд тодорхойлж байна.
- 7.4 Эрчим хүчний салбарын хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор цахилгаан, дулаан, үнэ тарифыг нэмэгдүүлэхэд салбарын ҮЭ-ийн холбоо дэмжлэг үзүүлж ажиллана.
- 7.5 Компанийн захирлын зөвлөлд ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, бүтэц зохион байгуулалт, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлсний асуудал зэргийг хэлэлцэхэд ҮЭ ийн хорооны даргыг зөвлөх эрхтэйгээр оролцуулна.

### **Найм. Хэлэлцээрийг биелүүлэх талаар**

- 8.1 Хэлэлцээр нь талууд гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн 2 жилийн хугацаанд хүчинтэй. Хэлэлцээрт талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө шинэ хэлэлцээр байгуулаагүй, эсвэл нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол талууд энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөнө.
- 8.2 Эрчим хүчний салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийн биелэлтийг талууд хагас бүтэн жилээр гаргаж, Эрчим хүчний яаман дээр хамтран дүгнэх бөгөөд талуудын төлөөлөгчдийн хамтарсан хурлаар хэлэлцэж холбогдох арга хэмжээг тухай бүр авч байна.
- 8.3 Эрчим хүчний яам, МЭХГҮҮ-н ҮЭ-ийн холбоо, ЭХА-ийн удирдлага, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, мөн шинэчлэн зохион байгуулагдах нь энэхүү хэлэлцээрийн дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн

залгамжлагчид энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

- 8.4 Хэлэлцээрээр хүлээсэн үүрэг зөрчигдсөн тохиолдолд аль нэг тал маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд төлөөлөгчдийн хуралдааныг 7 хоногийн дотор зарлан хуралдуулах эрхтэй.
- 8.5 Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг хэлэлцээ хийж шийдвэрлэхэд энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримталсан журмыг дагаж мөрдөнө.
- 8.6 Хэлэлцээрээр харилцан хүлээсэн үүргээ биелүүлэх явцад талуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс саад учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг талуудын саналаар хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 8.7 Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн маргааныг Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль” болон бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

---оо---



Эрчим хүчний сайдын 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/92 дугаар тушаалаар эрх олгогдсон төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгчид:

ЭХЯ-ны ТНБ-ийн дарга

Б.Насантогтох

ЭХЯ-ны ТЗУГ-ын дарга

Р.Батрагчаа

ЭХЯ-ны БТГ-ын дарга

Б.Ерэн-Өлзий

ЭХЯ-ны ЭХБХЗГ-ын дарга

Д.Батзориг

ЭХЯ-ны ХШУДАГ-ын дарга

Х.Бекболат

ЭХЯ-ны СХОГ-ын дарга

А.Энхбат

Эрчим хүчний сайдын зөвлөх

П.Товуудорж

ЭХЗХ-ны дарга

А.Тлейхан

ЭХЯ-ны ТЗУГ-ын САХС хариуцсан мэргэжилтэн

Д.Оюунчимэг

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Гүйцэтгэх хорооны II хуралдааны 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 06 тоот тогтоолоор эрх олгогдсон салбарын ажилчдын төлөөлөгчид:

Төлөөлөгчдийн ахлагч

МЭХГҮҮ-Н ҮЭ-ийн холбооны дарга

Х.Баянжаргал  
Төлөөлөгчид

МЭХГҮҮ-Н ҮЭ-ийн холбооны нарийн бичгийн дарга

Д.Долгор

“ДЦС-III” ТӨХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Д.Эрдэнэсайхан

“ДЦС-IV” ТӨХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Д.Ган-Эрдэнэ

“ЦДҮС” ТӨХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Д.Цэрэндамба

“УБЦТС” ТӨХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Ч.Өнөрцэцэг

“Да Дулааны сүлжээ” ТӨХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Г.Бадамгарав

“ДҮТ” ТӨХХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Д.Нацагдорж

“Хасу-Мегавагт” ХХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Б.Ариунбаатар

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны болон Монголын Эрчим хүчний ассоциацийн ерөнхийлөгчдийн 2021 оны 05 дугаар сарын 03-ны 01 тоот тушаалаар эрх олгогдсон салбарын ажил олгогч эздийн төлөөлөгчид:

МОНГОЛЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ  
АССОЦИАЦИИ ТНБ/

МЭХА-ийн ерөнхий нарийн бичгийн дарга

Mongolian Energy  
Association Пүрэвдорж  
УХ72874/07273

“ДЦС-IV” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Д.Темөрхуяг

“ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Б.Нямсамбуу

“ДБЭХС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Г.Отгонбаатар

“УБДС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Г.Баярсайхан

“Налайхын Дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Ц.Энхтувшин

“Даланзадгадын ДЦС” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Л.Банзрагч

“Алтай-Улиастайн ЭХС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Т.Ганзориг

“МЭЗ” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Д.Ганбаатар

